

Тав: Үйл ажиллагааны үр дагаврын үнэлгээ

5.1. Хэрэглэгчийн үнэлгээ

Засгийн газрын 2010 оны 11 дүгээр тогтоолоор батлагдсан “Яам болон аймаг, нийслэлийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх журам”-ын дагуу Хэрэглэгчийн үнэлгээг авахдаа Засаг даргын Тамгын газраас хөндлөнгийн мэргэжлийн судалгааны байгууллагад захиалга өгч гүйцэтгүүллээ.

Санал асуулгын асуултыг гаргахдаа Засгийн газрын болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, бусад бодлогын баримт бичгээр дамжин хэрэгжиж байгаа төрийн бодлого иргэдийн амьдралд ямар нөлөө үзүүлснийг харахыг зорилоо.

Дээрхи журмын дагуу Орхон аймгийн Мэдээлэл, сургалт судалгааны “Зууны мэлмий төв” төрийн бус байгууллага аймгийн насанд хүрсэн хүн амын 3.0 хувь буюу 1800 иргэнээс социологийн судалгаа авлаа.

Судалгааг доорхи асуултаар авлаа. Үүнд:

- Аймгийн Засаг даргын үйл ажиллагааг та хэрхэн үнэлж байна вэ
- Аймгийн Засаг даргын Тамгын газрын ажлын үр дүнг 2008 онтой харьцуулахад ямар түвшинд байна вэ
- Тулгамдаж байгаа 3 асуудлыг дугуйлна уу
- “Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх жил”-ийн хүрээнд хийсэн ажлын ажлын үр дүнг хэрхэн үнэлж байна вэ гэх мэт анкетын асуултын хамт 7 асуултаар авах чиглэл өгч ажилласан.

Санал-асуулгад оролцогчдын 28,8 хувь нь улсын үйлдвэрийн газарт (Эрдэнэт үйлдвэр ХХК, Дулааны цахилгаан станц, Цахилгаан түгээх сүлжээ компани, “Эрдэнэт ус УУГазар зэрэг), 28,0 хувь нь хувийн хэвшилд (“Хүрэнбулаг” үйлчилгээний төв, хүнс, барааны “Даниста”, “Есөн-Эрдэнэ”, “Ачит холдинг”, “Дөмөг, “Хүлэг” захууд, техникийн үйлчилгээний “Солонго” зах зэрэг), 33,0 хувь нь төсвийн байгууллагад (боловсрол, эрүүл мэндийн салбар болон төрийн байгууллагууд зэрэг) ажил эрхэлж байгаа нь Орхон

аймгийн иргэдийн ажил эрхлэлтийн бүтцийг бодитой илэрхийлсэн гэж үзэх бүрэн үндэстэй юм.

Судалгаанд хамрагдагсдын 41,6 хувь нь 18-35 насны залуучууд, 44,2 хувь нь 36-50 насны дунд үеийнхэн, 14,1 хувь нь 50-иас дээш насныхан, эмэгтэйчүүд 53,0 хувь байгаа нь аймгийн хүн амын насны болон хүйсийн бүтцийг үндсэндээ хангасан юм.Энэ удаагийн судалгаанд ажил эрхэлдэг хүмүүсийг илүү хамруулж зорилго тавьсан учраас тэтгэвэрийнхэн, оюутнууд, ажил эрхэлдэггүй хүмүүс харьцангуй бага (10%) хамрагдсан байна.

Судалгааны үндсэн асуудлаархи иргэдийн үнэлэмжийг үзүүлвэл:

1.Аймгийн Засаг даргын 2009оны үйл ажиллагаанд та ямар үнэлгээ өгөх вэ? гэсэн хаалттай асуултын позици бүрт дараах байдлаар хариулж үнэлгээ өгсөн байна.Үүнд:

Үнэлгээний хуваарь	Хариулсан тоо	Хувь
Бүрэн хангалттай	265	14,7
Хангалттай	740	41,1
Хангалтгүй	401	22,2
Мэдэхгүй	394	21,8
Нийт	1800	100,0

Эндээс үзвэл Орхон аймгийн иргэд аймгийн Засаг даргын 2009 оны ажилд хангалттай дүн тавьсан байна.Энд хэлэхэд иргэдийн үнэлгээний тархалт их байгаа юм.Тухайлбал: “бүрэн хангалттай” үнэлгээ (14.7%) , “хангалтгүй” үнэлгээ (22.2%), мэдэхгүй гэсэн үнэлгээ (21.8%) харьцангуй өндөр байна.

Эл байдал нь орон ургальч үзлийн илрэл боловч иргэдийн хүсэл тэмүүлэл, эрэлт хэрэгцээнд нийцсэн, далайцтай ажил цөөхөн байсныг давхар харуулж буй баримт юм.Иргэдийн 5/1 шахам нь Засаг даргын үйл ажиллагааг “мэдэхгүй” байгаа нь мэдээллийн хомсдолтой холбоотой байна.

Аймгийн Засаг даргын 2010 оны үйл ажиллагаанд хамгийн тодоор тэмдэглэгдсэн, Орхончуудад нийтэд хамааралтай ажил бол “Хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх жил”-ийн арга хэмжээ байлаа.Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлыг Эрдэнэт хотын нийтийн хөдөлгөөн болгож аймгаас 250,0 сая орчим төгрөг зарцуулж энэ чиглэлээр их ажил амжуулсан юм.

Судалгаанд оролцогчдоос ногоон байгууламжийг нэмэгдүүлэх жилийн ажлыг хэрхэн үнэлж байгаа талаар асуухад дор дурдсан хариултыг өгсөн юм.Хариултыг хамгийн их хувиас нь дараалуулан үзүүлбэл:

Дунд зэрэг	34,3%
Үр дүнтэй	29,6%
Тааруухан	18,2%
Үр дүнгүй	9,8%
Маш үр дүнтэй	8,0%

Энэ үр дүнгээс үзвэл ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлыг дундаас дээш үнэлсэн нь харьцангуй өндөр (71.9%) байна.Маш үр дүнтэй, үр дүнгүй гэсэн үнэлгээний үр дүн ойролцоо байгаа нь энэ ажлын үр дүнд сөрөг дүгнэлт гарахааргүй байгааг өгүүлсэн баримт юм.


Аймгийн Засаг дарга, түүний Тамгын газраас иргэдэд үзүүлж буй төрийн үйлчилгээний чанар хүртээмжийн талаар иргэдийн санал бодлыг сонсох нь зүйтэй гэж үзэж хаалттай асуултаар иргэдийн үнэлгээг авсан үр дүнг (дан болон давхар тоололтоор) харуулъя.

1.Дан тоололтын дүн

а.2008 онтой харьцуулахад сайжирсан	411	-22,8%
б.2008 оны түвшинд байгаа	860	-47,7%
в.2008 оны түвшинээс буурсан	529	29,3%

2.Давхар тоололтын дүн

Үндсэн объект Үнэлгээ	Улсын үйлдвэрт ажиллагсад		Хувийн хэвшилд ажиллагсад		Төсвийн байгууллагад ажиллагсад	
	Тоо	хувь	Тоо	хувь	Тоо	Хувь
2008 онтой харьцуулахад сайжирсан	76	14,6	99	19,6	202	34,0
2008 оны түвшинд байгаа	265	51,0	238	47,3	293	49,2
2008 оны түвшинээс буурсан	178	34,2	166	33,0	100	16,8
Нийт	519	100,0	503	100,0	595	100,0



Дан болон давхар тоололтын дүнгээс үзвэл 2009 онд төрийн үйлчилгээний хүртээмж чанар 2008 оныхоо түвшинд байна. Төрийн үйлчилгээний чанар хүртээмж сайжирсан гэсэн үнэлгээ төсвийн байгууллагад ажиллагсдад хамгийн өндөр (34.0), улсын үйлдвэрт ажиллагсдад хамгийн нам (14.6) байна.

Төрийн үйлчилгээ үзүүлдэг төр захиргааны болон боловсрол, эрүүл мэндийн байгууллагын ажиллагсдаас судалгаанд хамрагдсан 595 хүний 25,3% нь төрийн үйлчилгээний чанар хүртээмж 2008 оны түвшнээс буурсан гэж үнэлж байгаа нь анхаарал татаж байна.

Судалгаанд 2010 онд аймгийн Засаг дарга, түүний Тамгын газраас анхаарах гол асуудлыг 9 хариулт бүхий хаалттай асуултаар иргэдийн саналыг авсан дүнг тэдний саналын дарааллаар байрлуулж үзүүлье.

1.Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх	1011- 56,1%
2.Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах	774- 43,0%
3.Агаарын бохирдлыг бууруулах	645- 35,8%
4.Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих	546- 30,3%
5.Хот тохижилтыг сайжруулах	441- 24,5%
6.Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах	427 23,7%
7.Өрхийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх	397 22,0%
8.Бизнесийн орчинг сайжруулах	347 19,2%
9.Нийгмийн дэг журмыг сайжруулах	325 18,0%

